



АРГАЛАНТ СУМЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйл байвал 70272248
дугаарын утаснаас лавлана уу?
Л.Жаргалсайхан
Аймгийн Ерөнхий аудитор
өрөөний утас 70272582

Т.Майцэцэг - Ахлах аудитор
өрөөний утас 70273465

Аймгийн Аудитын газар
Төрийн байгууллагын ордон

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

- | | |
|---|-----|
| • Аудит хийж дууссан тухай мэдэгдэл | 2-3 |
| • Танилцуулга | 4 |
| • Санхүүгийн дотоод хяналт | 4-8 |
| • Гол шийдлүүд | 9 |
| • Тайлбар мэдүүлгийн захидал..... | 9 |
| • Аудитын санал дүгнэлт | 9 |

**Төв аймгийн Аргалант сумын төсвийн байгууллагууд,
тусгай сангууд 2013 оны Санхүүгийн Тайланд
аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Аргалант сумын төсөвт байгууллагууд болон тусгай сангуудын 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба Сумын Засаг дарга болон төсвийн шууд захирагч болон Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаархи бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Аргалант сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг тодруулбал:

- Орлого санхүүжилт, бараа ажил үйлчилгээний урсгал зардал, цалингийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө авлага, мөнгөн хөрөнгө, өглөг бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр дүнгээс гарсныг тодруулбал:

- Орон нутгийн төсвийн татварын орлогыг 37724.0 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 71881.4 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 34157.4 мянган төгрөгөөр буюу 190.5 хувиар давуулан биелүүлсэн байна.
- Хогны төлбөрийг Байгаль хамгаалах санд хуримтлуулж зарцуулсан байна.
- Орон нутгийн хөгжлийн сангаас ард иргэдийн саналыг авч эрэмбэлэгдсэн жагсаалтад ороогүй 13440.6 мянган төгрөгийг сумын Засаг даргын захирамжаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60-р зүйлийн 60.3.6-д орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээнд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулахыг хориглоно гэсэн заалтыг зөрчсөн байна.
-

*ЕМ, Санхүүгийн албанаас
ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын*

*Газар тайлбар мэдүүлэг хүлээж байгаа
илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар
тайлбар ирүүлнэ үү*

Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн, дээрх зөрчлүүд материалын урьдчилан тогтоосон түвшингээс бага тул Зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар Ерөнхий аудиторт санал оруулсан байгаа

- УАГазрын харьяа Төв аймгийн Аудитын Газрын дарга, Тэргүүлэх Аудитор 2014.03.24-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад нягтлан бодогч, нярав болон бусад албан тушаалтан бидэнтэй хамтран ажиллаж бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

**УАГ-ЫН ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

2014.03.21

Танилцуулга

Аргалант сумын 2013 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба сумын Засаг даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Бидний 2013 оны тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:

- Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
- Жилийн санхүүгийн тайланд аудит хийх;

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

Аймгийн Аудитын газар санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Аргалант сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын хяналтыг аймгийн Аудитын газрын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.

Бид Аргалант сумын Засаг дарга тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Аргалант сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын удирдлагын анхаарлыг хандуулж байна.

Орлого санхүүжилтийн талаар:

Аргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2012 оны 12-р сарын 19-ний өдрийн 02-р хуралдааны 01-р тогтоолоор сумын Орон нутгийн төсвийн татварын орлогыг 37724.0 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 71881.4 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 34157.4 мянган төгрөгөөр буюу 190.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Мөн аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого батлагдсан төлөвлөгөөгөөр 182615.1 мянган төгрөг, гүйцэтгэлээр 155409.9 мянган төгрөг буюу биелэлт 85.1 хувьтай, улсын төсөвт төвлөрүүлэх орлого төлөвлөгөөгөөр 73500.0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 105929.8 мянган төгрөг биелэлт 144.1 хувиар тус тус биелэсэн байна.

Төрийн сангийн төлөөлөгчийн гаргаж ирүүлсэн 2013 оны орлого, санхүүжилтийн нэгдсэн тайлангаар /нүүр тайлан/ Сумын орон нутгийн орлогын данс оны эхэнд 24607.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан. Тайлант онд орон нутгийн төсөвт төвлөрөх орлогоор 71881.4 мянган төгрөг төвлөрсөн ба НЕҮ-ний санхүүгийн дэмжлэгээр 231350.5 мянган төгрөг, нийт 303231.9 мянган төгрөг төвлөрч, санхүүгийн дэмжлэгээс ЗДТГазарт 147121.9 мянган төгрөг, ИТХуралд 45653.3 мянган төгрөг, Багт 38575.3 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс ЗДТГазарт 62424.8 мянган төгрөг буюу нийт 293775.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож үлдэгдэл 34063.6 мянган төгрөг байхаас 28846.4 буюу зөрүү 5217.2 мянган төгрөгийг ОНХСанд ИТХурлын тогтоол шийдвэргүйгээр шилжүүлэн зарцуулсан байна.

Тусгай зориулалттай шилжүүлгээр ЕБСургуульд 831118.5 мянган төгрөг, Цэцэрлэгт 269402.4 мянган төгрөг, Эмнэлэгт 237412.7 мянган төгрөг, Соёлын төвд 54744.9 мянган төгрөг нийт 1392678.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг нэгтгэсэн байна. Дээрх байгууллагуудын жилийн эцсийн зарцуулаагүй төсвийн үлдэгдэл 17391.3 мянган төгрөгийг, НЕҮйлчилгээний байгууллагуудын оны эхний харилцах дансны үлдэгдэл 4623.7 мянган төгрөгийг болон оны эцсийн зарцуулаагүй үлдэгдэл 4681.9 мянган төгрөгийг тус тус татан төвлөрүүлсэн байна

Халамжийн сангийн санхүүжилт 287184.4 мянган төгрөг төгрөгийг халамж үйлчилгээний санд төвлөрүүлснээс халамжийн тэтгэвэрт 209385,0 мянган төгрөг, жирэмсэн амаржсан эхийн тэтгэмжинд 57152,5 мянган төгрөг, хоол тэжээлийн тусламж дэмжлэгт 16210,0 мянган төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн зардалд 685,0 мянган төгрөг зарцуулсан байна. 3751,9 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэн байна

Нэмэлт төсвийн дансны санхүүжилтээр ЗДТГазарт 6695.9 мянган төгрөг, Сургууль 3861.8 мянган төгрөг, ЭМТөв 36,4 мянган төгрөг, Цэцэрлэг 2000.0 нийт 12594.1 мянган төгрөгийн орлого, 9654.8 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж оны эцэст 2639.3 мянган төгрөгийн үлдэгдэлийг мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд нэгтгэсэн. Нэгтгэлд ЗДТГазрын 240.7 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэгдсэн

Төсөвт байгууллагын өөрийн орлогоор Тамгын газарт 539.5 мянган төгрөг, Соёлын төв 1090.4 мянган төгрөг, ЭМТөв 585.3 мянган төгрөг, Сургууль 521.2 мянган төгрөг, нийт 2736.4 мянган төгрөг нэгтгэгдсэн байна.

Сум Хөгжлийн Санд 60000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн ХЭДСангийн данснаас төвлөрсөн сумын төрийн сангаар гүйлгээ хийгдээгүй байна

Мөнгөн хөрөнгийн талаар:

Сумын нэгдсэн тайлангаар оны эхэнд ЗДТГазар 5991.8 мянган төгрөг, ИТХурал 690.4 мянган төгрөг, Баг 179.5 мянган төгрөг нийт 6861.7 мянган төгрөг, Тусгай зориулалтийн сангууд 63722.7 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 24607.0 мянган төгрөг, эм эргэлтийн сан 3163.9 мянган төгрөг, ЭМТөв 35.7 нийт 98391.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан.

Жилийн эцсийн байдлаар Тусгай зориулалтийн сангууд 112271.8 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 28846.4 мянган төгрөг, эм эргэлтийн сан 7453.7 мянган төгрөг, Нэмэлт төсвийн санхүүжилтийн дансны үлдэгдэл 2939.3 нийт 151511.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна. Энэ Төрийн сангийн төлөөлөгчийн ирүүлсэн үлдэгдлийн баталгаагаатай болон ХААН банкнаас ирүүлсэн эм эргэлтийн сангийн үлдэгдлийн баталгаагаатай тохирч байна.

Авлага, өглөгийн талаар:

Сумын нэгдсэн тайлангаар Оны эхэнд 18833.8 мянган төгрөгийн авлага, оны эцэст 117247.7 мянган төгрөгийн авлагатай нэгтгэгдсэн ба оны эхнээс авлага 98413.9 мянган төгрөгөөр өссөн ба жилийн эцсийн нийт авлагын 113546.0 мянган төгрөгийн буюу 96.8 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байна.

Өглөг оны эхэнд 1704.6 мянган төгрөг, оны эцэст 2729.6 мянган төгрөгийн өглөгтэй нэгтгэгдсэн байна. Оны эцэст ЭМТөвийн түлш халаалтын өглөг 2686.2 мянган төгрөг нийт өглөгийн 98.4 эзэлж байна

Бараа материал

Сумын нэгдсэн тайлангаар Бараа материалын данс нь оны эхэнд 149611.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 421337.9 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 426221.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, жилийн эцэст 144728.3 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө

Сумын нэгдсэн тайлангаар Үндсэн хөрөнгийн данс нь оны эхэнд 4521910.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 1280087.7 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 76572.3 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж, жилийн эцэст 5725426.2 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна. Тайлант онд байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдэл 11319.2 мянган төгрөг үлдэх өртөг 3894157.1 мянган төгрөг байна

Тусгай зориулалтын сангууд

Сумын хэмжээнд 7 сан үйл ажиллагаа явуулж байгаа ба эм эргэлтийн сангаас бусад сан Төрийн сангийн харилцах дансаар гүйлгээ хийгдэж хянагддаг байна. Сангуудыг тодруулахад:

Байгаль хамгаалах сангийн талаар:

Тус сангийн харилцах данс нь оны эхний үлдэгдэл 559.3 мянган төгрөг байснаас тайлант оны турш 17518.1 мянган төгрөгний орлого санхүүжилт төвлөрч бүрдэл болсон 30 ширхэг төлбөрийн даалгавраар 11890.0 төгрөг зарцуулж дансанд 6187.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. БХСангийн санхүүгийн тайлангаар Өглөг: Иргэн Б.Батболд, Д.Эрдэнэсүрэн, Л.Оюунцэцэг нарын материалын үнээс суутгасан албан татварын үнэ 43.4 мянган төгрөгийг татварын орлогын дансанд шилжүүлэхийг өглөгөөр бүртгэсэн байна
Авлага: Иргэн Д.Батболд, У.Энхболд нарын төсөл бүрэн хэрэгжиж дуусгавар болсны дараа сангийн үндсэн хөрөнгөнд бүртгэх тул авлагаар тайлагнасан байна
Аудитын явцад ирүүлсэн тайлбараар үнэт цаасанд 170.0 мянган төгрөгөөс 90.0 мянган төгрөгийн үнэт цаасны үлдэгдлийг няравт орлогоод бараа материалын дансанд үлдэгдлээр тайлагнасан. Харин 80.0 мянган төгрөгийн үнэт цаасны тооцоог хийгээгүй авлагаар бүртгэсэн байна.

Байгаль хамгаалах сангийн эх үүсвэрийг дараахь байдлаар бүрдүүлсэн байна. Үүнд:

Зөвшөөрөлгүй мод бэлтгэсэн нөхөн төлбөрт $910440+566496+3600000=5076.9$ мянган төгрөг, Торгууль 421.2 мянган төгрөг, Хог ачуулсны хураамж ЭМТөвөөс 20.0 мянган төгрөг, Аймгаас байгаль орчныг хамгаалах ажилд 12000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг Нийт 17518.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2013 оны аймгийн төсвөөс 12000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг ирүүлснээс батлагдсан төлөвлөгөөний дагуу дараах зүйлд зарцуулсан байна. Үүнд:

1. Хог хаягдлыг ангилан ялгах зориулалттай хогийн сав олж бэлтгэхэд 3000.0 мянган төгрөг
2. Ан амьтны байршил толгойн тоог тогтоох зорилгоор мониторингийн цэгийг тогтоох, тэмдэг тэмдэглэгээ хийх, мөн бүх нийтийн хог цэвэрлэгээнд оролцсон албан байгууллагуудын алба хаагч нарын хоол хүнсэнд зориулж 637.7 мянган төгрөг
3. Гол горхи булаг шандны эхийг хамгаалах, энгийн хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх зорилгоор Далын рашааныг хамгаалах, химийн элементийн жагсаалт бүхий тэмдэг байрлуулахад 2060.0 мянган төгрөг
4. Гарал үүслийн гэрчилгээ, мод бэлтгэх эрхийн бичиг, байгал орчны багц хуулийг суртчилах иргэдэд таниулах зорилгоор гарын авлага, бичгийн цаас зэрэг бичиг хэргийн зардалд 209.3 мянган төгрөг
5. Хавар намрын хуурайшилтын үед удаа дараа хяналт шалгалт хийх, байгалийн жамаар унасан мод цэвэрлэх, сумын төвийн ил задгай хог цэвэрлэж ачих, нэгдсэн хогийн цэгийн хальсан хогийг түрж цэгцлэх зэрэг ажлуудыг хийхэд зарцуулсан тээвэр шатахууны зардал $5141.5 - 997.9 = 4143.6$ мянган төгрөг Нийт 10050,6 мянган төгрөг

Орон нутгийн хөгжлийн сангийн талаар:

Орон нутгийн хөгжлийн сангийн 140952400 тоот дансыг Төрийн санд нээж тайланд онд 144000.7 мянган төгрөгийн орлого, 43178.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж жилийн эцэст харилцах дансанд 100822.1 мянган төгрөгний үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Орлогыг ня-бо-оос тодруулахад улсын төсвийн санхүүжилт 89966.0 мянган төгрөг, Хатуу хучилттай 0.92 км зам засварлахад сумын ард иргэд албан байгууллагаас хандив 40639.2 мянган төгрөг, Нийгмийн хариуцлагын гэрээний төлбөр 6992.0 мянган төгрөг, Аргалант хөгжил сангийн зээлийн төлбөрт Иргэн Л.Бямбаагаас 200.0 мянган төгрөг, .Аргалант хөгжил сангийн үлдэгдэл, өрхийн үйлдвэрлэлийн бүгд 1027.8 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн, Хог хаягдлын хураамжийн орлогыг буцаан төвлөрүүлсэн 4321.9 мянган төгрөг, андуурсан 853.8 мянган төгрөгийн бүгд 144000.7 мянган төгрөг ба буцсан гүйлгээг хасч тооцоход мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх Хөрөнгө оруулалтын эрэмбэлсэн жагсаалтыг сумын ИТХурлын 05-р хуралдаанаар 2013.04.04-ний өдрийн 01 тоот тогтоолоор 6 төсөл хөтөлбөрт 194.0 сая төгрөгөөр баталсан. Аймгийн хэмжээнд олгох санхүүжилт буурсантай холбогдуулан сумын ИТХурлын 2013.12.05-ний өдрийн 02 тоот тогтоолоор 4 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр 163.5 сая төгрөгийг баталсан байна.

Тайлант онд ОНХСангийн санхүүжилтэнд 89966.0 мянган төгрөгийг олгосон СТСХэлтсээс ирүүлсэн тулган баталгаажуулалтаар 89965.9 мянган төгрөг буюу 0.1 мянган төгрөг зөрүүтэй байна. Тайлант оны санхүүжилтээс 29360.0 мянган төгрөгийн ажил хийгдсэн 60606.0 мянган төгрөгийн ажил хийгдээгүй байна. Хөрөнгө оруулалтын хийгдсэн ажлыг тодруулахад:

Соёл спортын цогцолборын барилгын иж бүрэн зураг төсөл хийлгэх ажлыг Худалдан авах ажиллагааны журмыг баримтлаагүй сонгон шалгаруулалт явуулаагүй Ди Эл Ти ХХКомпанитай 2013.08.09-ний өдөр Барилгын зураг төсөл боловсруулах талаар ... мянган төгрөгийн гэрээ байгуулсан байна. Гэрээгээр уг ажлыг календарийн 25 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ гэж заасан. Соёлын төвийн барилгын зураг хийхэд 19360.0 мянган төгрөг олгосон байна.

Засмал замын зураг төсвийн хийлгэх гэрээ байхгүйгээр 2013.05.17-ний өдөр Ти Ай Би ХХК –д 1 км замын зураг төсвийн урьдчилгаанд 2000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна. Гэрээ хэлэлцээ байхгүй тул ажлын гүйцэтгэл тодруулахад Хатуу хучилттай 0.92 км замын зураг төсвийг Ти ай би ХХК-аар хийлгэсэн ба нийт өртөг 459433.3 мянган төгрөг байна.

Баяр наадмын зардалд 8.0 сая төгрөг зарцуулахаар тусгаж аймгийн 90 жилд 3500.0 мянган төгрөгийг, сумын баяр наадамд 4908.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

ОНХСангаас ард иргэдийн саналыг авч эрэмбэлэгдсэн жагсаалтад ороогүй дараахь гүйлгээг сумын Засаг даргын захирамжын дагуу зарцуулсан байна. Үүнд: Үндэсний бичиг үсгийн баярт 368.0 м/т, Газар тариалангийн зөвлөгөөнд 1358.0, Сургууль самбарт 1500.0м/т, Ахмадын баярт 2500.0 м/т, Хог хаягдал 3 хүнд цалин, шимтгэл шатахуун 5577.0 м/т, Хүүхдийн баяр 353.8 м/т бүгд 13440.6 м/т зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60-р зүйлийн 60.3.6-д орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээнд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулахыг хориглоно гэсэн заалтыг зөрчсөн байна

Мал хамгаалах сангийн талаар:

Тайлант хугацаанд мал хамгаалах сангийн харилцахын эхний үлдэгдэл 1349.6 мянган төгрөг байсан ба тайлант онд 5708.0 мянган төгрөг төвлөрсөн байна. Үүнд:

2012 онд 4 Багийн Засаг дарга нарт 4000.0 мянган төгрөгийг 3 хувийн хүү 120,0 мянган төгрөг буюу 4120.0 мянган төгрөг тушаахаас 3368.4 мянган төгрөг тушааж 751.6

мянган төгрөг дутуу байна. Мөн онд Өгөөмөр багийн иргэн Бавуудоржид өвс бэлтгэж иргэдэд худалдах зорилгоор 2500.0 мянган төгрөгийн зээлийг 2012 онд олгосон зээлийн эргэн төлөлт 1030.0 төгрөг хугацаандаа төлөгдсөн ба 1500.0 мянган төгрөгийг хүүгийн хамт 2014 оны 10-р сард тушаана. 2013 онд зээлийн хүү 45.0 мянган төгрөг дутуу тушаагдсан байна

Тайлант онд 1349.6 мянган төгрөгийн өвсийг багийн Засаг дарга Нямхүү, Хоролсүрэн нар тарааснаас 1309.6 мянган төгрөгийг тушааж 40.0 мянган төгрөг дутуу тушаагдсан байна.

2013 онд 5806.6 мянган төгрөг зарцуулсан байна. Үүнд: тээвэр шатахууны зардалд буюу өвс бэлтгэх, хорголжин тэжээл татахад зориулж 840.0 мянган төгрөг, Сумын өвс тэжээлийн аюулгүй байдал хангах нөөц бүрдүүлэх зорилгоор иргэн Ю.Байгалмаад /1282 боодол нэг бүрийн үнэ 2300 төгрөг/ 2948.6 мянган төгрөг, Аймгийн УНСалбараас 560.0 төгрөгний 100 уут хорголжин тэжээл худалдан авсны үнэнд, 2013 оны 1 дүгээр сард аймгийн УНСалбараас 299 боодол өвс татаж захиалгын дагуу малчдад хүргүүлж өвсний үнэ 1349.6 мянган төгрөг, Төрийн санд орлого залруулав 108.4 мянган төгрөг тодруулах

2013 оны жилийн эцэст харилцах дансандаа 1251.0 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын явцад өвсний тайлан тооцоог гаргаагүй байсан тул МЭҮТасгийн мэргэжилтэн Энхбаяр нь ирж тайлбар өгөв. Үүнд 2013 онд Ю.Байгалмаагаас авсан 1282 боодол өвсийг 2300 төгрөгөөр ирснийг 4000 төгрөгөөр, УНСалбараас ирсэн хорголжин тэжээлийг 5600 төгрөгөөр ирснийг 9000 төгрөгөөр худалдах шийдвэрийг Засаг даргын өрөөнд ярилцаад тогтоосон. 2014 оны 1.2-р сард борлуулсан. Одоо борлуулагдаагүй үлдэгдэл 708 ширхэг өвс байна. Борлуулалтаар 3196.0 мянган төгрөг тушаахаас 225.0 мянган төгрөгийг МХСанд тушааж 2971.0 мянган төгрөгийг тушаагаагүй өвс тэжээлийг зээлээр олгосон одоо мөнгийг авч тушаана. 2013 оны 1-р сард Зуунмод УНСалбараас 1 боодол өвсийг 4500 төгрөгөөр ирснийг багийн 2 Засаг дарга тараасан байна. Өвс тэжээлийн тооцоог сар улиралд хийж байх шаардлагатай байна.

Сүм хөгжүүлэх сангийн талаар:

Сум хөгжүүлэх сан нь оны эхэнд 58275.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба санхүүгийн дэмжлэг 60000.0 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдсэн ба зээл, зээлийн хүүний эргэн төлөлтөөс 52642.9 мянган төгрөг нийт 112642.9 мянган төгрөг төвлөрсөн ба 170833.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэнээс 83 хүнд 169800.0 мянган төгрөгийн зээлийг олгосон ба ОНХСанд 600.0 мянган төгрөгийг, үйл ажиллагааны зардалд 150.0 мянган төгрөгийг, 33.4 мянган төгрөгийг шатахууны зардалд олгосон байна.

Байгаль орчин нөхөн сэргээлтийн сангийн талаар:

Баримт ирүүлээгүй болно. Санхүүгийн тайлангаар

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан хэсгүүдийн дотоод хяналтын систем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах
- Санхүүгийн тайлан гаргалт уялдаа холбоог сайжруулах

- МУ-ын ЗГазрын 2012.11.09–ний өдрийн 311-р тогтоолыг хэрэгжүүлэн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг батлан мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

1. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар илрүүлсэн алдаануудыг төсөвт байгууллагуудад залруулсан ба нэгтгэлд залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

2. Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн даргаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

3. Аймгийн Аудитын газраас танай байгууллагын 2013 оны 12 дугаар сарын 31 –нээр тасалбар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайланд **зорчилгүй** санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар

2014.03.22